



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД:
ОРА-2024/19-13-
ШТА-ГА

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО,
ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛЖ,
ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088
Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805
Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955
Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70355805
Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn
Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955
Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товъёг.....	3
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл	4

БҮЛЭГ 1. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГААР ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ТОДОРХОЙ АХИЦ ДЭВШИЛ ГАРСАН Ч ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА..... 7

Яам, агентлаг, аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын бүтцийг Засгийн газраас, бусад байгууллагуудын бүтцийг дээд шатны төсвийн захирагч болон үлгэрчилсэн дүрэм, жишиг стандарт, норм нормативын дагуу тогтоож байна.	7
Аймгийн ЗДТГ-н орон тоо нь Засгийн газраас тогтоосон хязгаараас төрийн үйлчилгээний албан хаагчдын тооноос хамааран хэтэрсэн байна.	8
Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо бүрэн хангагдаагүй байна. 10	
Хүний нөөцийн бодлогын цогц баримт бичиг батлаагүй, төрийн албаны хүний нөөцийн бодлогод хяналт үнэлгээ хийгээгүй байна.	11
Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо хангалттай ч нарийн мэргэжлийн орон тоог нөхөх иргэн ховор байна.	12
Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.	13
Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулж баталсан ч төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалын тодорхойлолтыг хянадаггүйгээс байгууллагын удирдлага албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагыг тодорхой тусгахгүй баталж байна.	14
Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийгээгүйгээс албан тушаалын давхардал, хийдлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна... 14	
Холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоолоор тусгайлан зохицуулснаас бусад нийгмийн баталгаагаар тухайн байгууллагын онцлог, төсөв санхүүгийн боломжоос хамааран харилцан адилгүй хангагдаж байна.	21
Сул орон тооны томилгоог зарим тохиолдолд Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.	23
Төрд хохирол учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх шаардлагатай байна.	28

БҮЛЭГ 2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА. ... 33

Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан цахим болон танхимаар сургаж байна.	33
Төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон зохицуулалтын хүрээнд шилжүүлэн ажиллуулсан байна.	35
Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна.	35

Төрийн байгууллагын цахимаар үзүүлж буй үйлчилгээг иргэд хүлээн авах боломж, бололцоог олгох талаар арга хэмжээ авч ажиллаж байна.	38
Төрийн захиргааны байгууллагын үйлчилгээ жигд, эрүүл мэнд, боловсролын байгууллагын үйлчилгээ харилцан адилгүй байна.	39
Төрийн үйлчилгээ цахимжсан нь төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирч байна. ...	40
Авлигатай тэмцэх газраас хийлгэсэн судалгааны тайлангаар Орхон аймгийн ЗДТГ-н шударга байдлын үнэлгээ 2015 оноос 2022 онд 9 байраар сайжирсан байна.	40
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	43
ЗӨВЛӨМЖ:	44
Аудитын тайлан баталгаажуулах тушаал:	46
Холбогдох байгууллагын санал:	47
Хавсралтууд:	49

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БОГ	Байгаль орчны газар
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
НДГ	Нийгмийн даатгалын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
УИХ	Улсын их хурал
УЦУОШТ	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
УТ	Улс төр
ХАСУМ	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
ХОХБТ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ХТГ	Хот тохижуулах газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТЗ	Төрийн захиргаа
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ТТ	Төрийн тусгай

ТУ	Төрийн үйлчилгээ
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	ЗДТГ-н баталсан орон тооны албан тушаалын ангидал	17
2	Төрийн албан хаагчийн бүтэц орон тооны судалгаа	18
3	ЭМГ-ийн мэргэжилтний томилгоо	24
4	АЗДТГ-н ахлах мэргэжилтний томилгоо	25
5	Нөөцөд бүртгэлтэй албан хаагчийн судалгаа	31
6	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан судалгаа	33
7	Сургалтад хамрагдсан мэдээлэл	34
8	Сургалтын тооны хязгаар	35
9	Жендерийн судалгаа	36

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн иргэдийн тоо	13
2	Аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоо	16
3	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо	16
4	Жаргалант сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо	16
5	Гэрээтээр ажилласан албан хаагчийн тоо, олгосон цалин	19
6	Шүүхэд гаргасан нэхэмжлэхийн мэдээлэл	29
7	Эмэгтэйчүүдийн ТА эрхлэлт /хувиар/	36
8	ХБИ-н эзлэх хувийн жингийн диаграмм	37
9	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд ажил олгогчоос төвлөрүүлсэн ХБИ-н төлбөр	38
10	Аймаг, нийслэлийн авлигад өртөх эрсдэл болон авлигын индекс	41
11	Аймгуудын шударга байдлын үнэлгээний үзүүлэлт. /хувиар/	42
12	Монгол Улсын авлигын төсөөллийн индекс. /2013-2023 он/	42

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрхзүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг төрийн захиргааны, төрийн тусгай, улс төрийн, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг ажиллуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, батлуулж, мөрдөж байгаа байдлыг аймаг, сумдын ИТХ, холбогдох байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлээ. Аудитад нийт 13 орон нутгийн байгууллага, 82 босоо тогтолцоотой байгууллагыг хамруулж, төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн бодлогын, хяналт шинжилгээ дотоод аудитын албад нь өөрийн болон өөрт хамаарах хүний нөөцийн бодлогыг зөв тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг 2013-2023 оныг хамруулан үзлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад

заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Тухайн аудитын зорилтыг хангахад чиглэсэн аудитын асуудлын шинжилгээнд тусгагдсан асуултууд (*Хавсралт 2*);
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Авлигын эсрэг хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
- Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Б.Бямбатогтох, Ц.Одгэрэл нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль нь анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Дээрх хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулж, хамгийн сүүлд 2020 оны 01 дүгээр сарын 3-ны өдөр хуульд нэмэлт оруулсан байна.

УИХ-ын 1996 оны “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлогын тухай” 38 дугаар тогтоолыг баталсан байна. Уг тогтоолоор Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг зөвшөөрч, 1996 оноос эхлэн хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгажээ.

Төрийн албаны төв байгууллагын гаргасан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлээр Орхон аймагт 2023 онд 5007 албан хаагч бүртгэгдсэн байна. Үүнээс:

- Төрийн улс төрийн албан тушаалд 122 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 2.4 хувь;
- Төрийн захиргааны албан тушаалд 449 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 9.0 хувь;
- Төрийн тусгай албан тушаалд 79 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 1.6 хувь;
- Төрийн үйлчилгээний албан тушаалд 4357 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 87.0 хувийг тус тус эзэлж байна.

Орхон аймгийн төрийн албанд 2013 онд 3.8 мянган төрийн албан хаагч ажиллаж байсан бол 2023 онд 5.0 мянган төрийн албан хаагч ажиллаж, 1.2 мянгаар нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГААР ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ТОДОРХОЙ АХИЦ ДЭВШИЛ ГАРСАН Ч ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Яам, агентлаг, аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын бүтцийг Засгийн газраас, бусад байгууллагуудын бүтцийг дээд шатны төсвийн захирагч болон үлгэрчилсэн дүрэм, жишиг стандарт, норм нормативын дагуу тогтоож байна.

Яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тооны дээд хязгаарыг тухай бүр Засгийн газрын тогтоолоор баталж¹ байна.

Тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тооны хязгаарыг Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор² баталж, түүнээс хойш холбогдох өөрчлөлтүүдийг тухай бүр оруулж баталсан байна.

2006 онд баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.3³-д заасны дагуу хурлын байгууллагын бүтэц, орон тоог Тэргүүлэгчид өөрөө, 33.2⁴-д заасны дагуу аймгийн ЗДТГ-н бүтэц, орон тооны хязгаар, сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг Засгийн газрын тогтоолоор тус тус баталж байсан. 2020 онд баталсан хуулийн шинэчилсэн найруулгаар /54.2⁵/ аймаг, сумын ИТХ-н ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө, /67.2⁶/ аймаг, сумын ЗДТГ-н бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтоож байна.

¹ Засгийн газрын 2022 оны 76 дугаар тогтоол: “Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай”.

² Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол: “Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай”

³ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн /2006 онд баталсан хуучин/ 20.3-д “Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно”

⁴ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн /2006 онд баталсан хуучин/ 33.2-д “Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтоох бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэлтэс, тасагтай байна”.

⁵ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 54.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно”

⁶ Мөн хуулийн 67.2-д “Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна”

Боловсролын байгууллагын бүтэц, орон тоог тухайн байгууллагын хүчин чадал, анги, бүлэг, хүүхдийн тоо, дээд байгууллагын баталсан хичээлийн хөтөлбөр, агуулга, цагийн норм, норматив хүрээнд захирал, эрхлэгч нар өөрсдөө баталж байна.

Аймгийн ЗДТГ-н орон тоо нь Засгийн газраас тогтоосон хязгаараас төрийн үйлчилгээний албан хаагчдын тооноос хамааран хэтэрсэн байна.

Аймаг, сумдын ЗДТГ, ИТХ-ийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг Засгийн газраас тогтоохдоо төрийн захиргааны албан хаагчийн дээд хязгаарыг тогтоож байна.

Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол⁷, түүнд оруулсан өөрчлөлтүүдийн хүрээнд сумын ЗДТГ-н орон тооны дээд хязгаарыг Жаргалант 16, Баян-Өндөр 23 байхаар тогтоож одоо хүчинтэй хэвээр байна.

Аймгийн ЗДТГ нь Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор 37 хүртэл, 2016 оны 9-р тогтоолоор 41 хүртэл, 2021 оны 377 дугаар тогтоол⁸, түүнд оруулсан өөрчлөлтүүдээр 57 хүртэл орон тоотой байхаар тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга жил бүр Засгийн газрын тогтоосон дээрх орон тооны дээд хязгаарт тулган төрийн захиргааны албан хаагчдыг орон тоог тогтоож, зарим хэлтэс, нэгжид зарим албан хаагчийг төрийн үйлчилгээний албан хаагч байхаар бүтэц, орон тоог баталж байна.

Тухайлбал: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтнийг аймгийн ЗДТГ-н даргын 2013.12.25-ний өдрийн А/175 дугаар тушаалаар ТЗ, 2015.03.03-ний өдрийн А/15 дугаар тушаалаар ТҮ, 2016.11.02-ний өдрийн А/95 дугаар тушаалаар ТЗ-ний албан тушаалын ангиллаар баталсан байна.

Мөн аймгийн ЗДТГ-н даргын 2017.01.25-ний өдрийн А/06 дугаар тушаалаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэст Зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтны /ТҮ/ орон тоог баталж, тухайн орон тоонд 2017.02.01-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар албан хаагчийг томилж тус албан хаагч нь ажиллаж байх хугацаандаа ИТХ-

⁷ Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоол: “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” 1. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг ... , 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, ... , 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай. /Энэ заалтыг Засгийн газрын 2017 оны 253, 2018 оны 267 дугаар тогтоолоо тус тус өөрчлөн найруулсан.

⁸ Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол: “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 57 хүртэл, ... орон тоотой байхаар тус тус тогтоосугай.

ийн ажлын албаны сул орон тоонд 2018.12.24-ний өдөр ТЖАХ-ийн шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн байна.

Иймд аймгийн ЗДТГ-н даргын 2018.12.31-ний өдрийн А/130 дугаар тушаалаар дээрх анх зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан /ТҮ/-ээр баталсан албан тушаалыг зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн /ТЗ/-ийн орон тоогоор баталж, Орхон аймаг дахь Салбар зөвлөлийн 2018.12.31-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор тус албан хаагчийг ажиллаж буй албан тушаалд нь буюу аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, аймгийн ЗДТГ-н даргын 2018.12.31-ний өдрийн Б/39 дугаар тушаалаар төрийн жинхэнэ албан тушаалд томилж, ТЖАХ-ийн тангараг өргүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Аймгийн ЗДТГ-ийн зарим хэлтсүүдэд холбогдох асуудал хариуцсан ажилтан нэрээр ТҮ-ийн албан тушаал баталж ажиллаж байна. Тухайлбал: НБХ-ийн ахмад настан, биеийн тамир, спортын асуудал хариуцсан ажилтан ТҮ-ээр, ХОХБТ-ийн гадаад харилцаа, төсөл хөтөлбөр хариуцсан ажилтнууд ТҮ-ээр гэх мэт.

Иймд Засгийн газраас аймаг, сумын ЗДТГ, ИТХ-н бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоохдоо тухайн шатны ЗДТГ-н болон ИТХ-н ажлын албаны төрийн үйлчилгээний албан хаагчдын тооны дээд хязгаарыг оруулан нийт албан хаагчийг тоогоор бүтэц, орон тоог батлах нь зүйтэй байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл”-ийн хүрээнд Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл, орон тоог аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж ажилласан байна.

Ингэхдээ аймгийн Засаг даргын 2018 оны А/197, 2019 оны А/413 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтэц орон тоог албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр батлаагүй тул Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 2021 оныг хүртэл тухайн хэлтсийн аль нэг чиг үүргийн мэргэжилтнийг хэлтсийн даргаар давхар томилж, үйл ажиллагаа явуулж байжээ. Үүнд:

Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний орон тоонд хүний оронд түр томилогдсон албан хаагчийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнээр томилж, тухайн албан хаагч нь тус хэлтсийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал хариуцсан мэргэжилтнээр шилжин ажиллахад хэлтсийн дарга нь дагаад удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга,

эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудал, шагнал хариуцсан мэргэжилтнээр шилжүүлэн томилсон байдаг.

Орхон аймгийн Засаг даргын 2021 оны “Аймгийн эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог батлах тухай” А/253 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газар нь хэлтсийн даргагүй, хэлтэс нь ахлах мэргэжилтэнтэй байхаар орон тооны дээд хязгаарыг албан тушаалын ангилал, зэрэглэл тус бүрээр тогтоон баталж, 2023 оны А/84 дүгээр захирамжаар мөн адил хэлтсийн даргагүй, хэлтэс нь ахлах мэргэжилтэнтэй байхаар шинэчлэн баталсан байна.

Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо бүрэн хангагдаагүй байна.

Төрийн албаны хүний нөөцийн бодлоготой холбоотой бодлогын зорилтууд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар тодорхойлогдсон байна. Үүнд:

Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-ийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба”-н зорилт 5.4-д “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

УИХ-н 2020 оны 23 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба”-н зорилт 5.4-д “Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн ИТХ-н 2020 оны 02/01 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “Хариуцлагатай төрийн алба”-н зорилт 5.2-д “Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхыг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэд салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн 4 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.7-д “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг байхаар тусгасан байдаг.

Эдгээр баримт бичгүүдэд тусгасан бодлогын зорилтуудыг харьцуулан авч үзвэл хоорондын уялдаа холбоо бүрэн хангагдаж тусгагдаагүй байна. Орхон аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.4.5⁹, 5.4.6¹⁰ дахь зорилт, “Алсын хараа 2050”-ийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.4.2¹¹, 5.4.3¹², 5.4.6¹³, 5.4.7¹⁴, 5.4.8¹⁵, 5.4.14¹⁶, 5.4.16¹⁷, 5.4.17¹⁸ дахь зорилтын агуулгууд орон нутгийн онцлогт тохирсон байдлаар тусгагдаагүй байна.

Хүний нөөцийн бодлогын цогц баримт бичиг батлаагүй, төрийн албаны хүний нөөцийн бодлогод хяналт үнэлгээ хийгээгүй байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-ийн хүрээнд “2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-г тогтоолын 2 дугаар хавсралтаар баталж, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлж УИХ-аар

⁹ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл: 5.4.5.төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ.

¹⁰ 5.4.6.төрийн үйл ажиллагааны бүхий л шатанд Шилэн дансны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг дээдлэн ажиллаж, холбогдох хуулийн дагуу иргэний шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын удирдлагад хариуцлага тооцдог болно.

¹¹ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: 5.4.2.Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

¹² 5.4.3.Төрийн байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулна.

¹³ 5.4.6.Төрийн жинхэнэ албан тушаалд томилоход мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын үр дүн, улс болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг харгалздаг уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.

¹⁴ 5.4.7.Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран шатлан дэвших зарчмаар төрийн албанд ажиллах нөхцөл, баталгааг бүрэн хангасан улс төрийн, хууль, эрх зүйн, эдийн засгийн тогтолцоог бэхжүүлнэ.

¹⁵ 5.4.8.Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлнэ.

¹⁶ 5.4.14.Төрийн албаны сургалтад мэдээллийн технологид суурилсан олон хувилбарт аргуудыг нэвтрүүлнэ.Танхимын сургалтаас гадна цахим болон зайн сургалт, ажлын байранд сургах, цахим сургалтыг төрийн албаны орчин үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.

¹⁷ 5.4.16.Төр-үйлчилгээний чанарын хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжинэ.

¹⁸ 5.4.17.Төрийн үйлчилгээний зардал, үр ашгийн тооцоо гаргаж, төрийн бодлого, шийдвэрт тусгаж хэрэгжүүлдэг, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, санхүүжилт, үр нөлөөний байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэд, олон нийтэд мэдээлдэг тогтолцоонд шилжүүлнэ.

батлуулахыг Засгийн газарт үүрэг болгон, хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, УИХ-д танилцуулахаар тусгасан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.5-д орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр нь орон нутгийн чиг үүрэгт, 21.1.6-д аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр нь аймгийн чиг үүрэгт, 22.1.6-д аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл сумын чиг үүрэгт хамаарахаар тус тус тусгасан.

Орхон аймгийн тухайд хуулийн дээрх чиг үүргийн хүрээнд орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийн тухайлсан баримт бичиг батлаагүй байна.

Аймгийн ИТХ-н 2022 оны 13/05 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж, аймгийн Засаг даргын 2023 оны А/811 дугаар захирамжаар “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн ажиллах журам”-ыг баталж 2023 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.


Төрийн албаны зөвлөл, Орхон аймаг дахь Салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоотой холбоотой асуудлаар шалгалтуудыг тогтмол хийж ажиллаж байна.

Засгийн газрын “Шүүр” ажиллагааны хүрээнд хүргүүлсэн чиглэлийн дагуу төрийн байгууллагуудын удирдлага байгууллагадаа болон тэдгээрийн дээд газруудаас уг ажиллагааг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийн мөрөөр холбогдох арга хэмжээнүүдийг авсан байна.

Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо хангалттай ч нарийн мэргэжлийн орон тоог нөхөх иргэн ховор байна.

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдан хэрэгжиж эхэлснээр төрийн албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулдаг болсноор төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэх иргэдийн тоо өссөн бөгөөд үүнтэй холбоотойгоор төрийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ нэмэгдсэн байна. Орхон аймагт 2019 онд төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулахад 325 иргэн шалгалтад орсноос 42 иргэн буюу шалгуулагчдын 13 хувь нь тэнцэж байсан бол 2023 онд 336 иргэн шалгалтад орсноос 136 иргэн буюу шалгуулагчдын 40 хувь нь тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн байна.

Дүрслэл №01 Төрийн албаны ерөнхий шалгалтын тоо мэдээлэл



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан

Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо хангалттай боловч нарийн мэргэжлийн (малын эмч, мал зүйч, багш, соёл урлагийн мэргэжилтэн, геодези зураг зүй гэх мэтчилэн) орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэн ховор байна.

Төрийн үйлчилгээний байгууллагууд удирдах албан тушаалтнуудаасаа бусад сул орон тоо нөхөх зарыг өөрийн цахим хуудсаар зарладаг бөгөөд албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагаа хэт өндрөөр тавьдгаас хүний нөөц хүрэлцээгүй, олдохгүй гэх шалтгаанаар албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлага хангахгүй иргэнийг сонгон шалгаруулалтгүй хөдөлмөрийн гэрээ байгуулдаг зөрчил гарсаар байна.

Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹⁹, 8.5²⁰-д заасны дагуу мэдээлэл хариуцагч төрийн байгууллагууд хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд болон олон нийтийн сүлжээн дэх өөрийн цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байнга байршуулж хэвшсэн бөгөөд цахим технологи хөгжихийн хэрээр дээрх мэдээллийг контент, инфографик хэлбэрээр үйл ажиллагааны ил тод байдлаа сурталчлан ажиллаж байна.

¹⁹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1-д “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана

²⁰ 8.5-д “Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана”

Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллага хооронд болон иргэн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр харилцахад ашиглагдах нийтийн мэдээллийн систем e-mongolia, e-health, e-halamj, e-gazar зэргээс цаг хугацаа, орон зайн байршил харгалзахгүйгээр төрийн үйлчилгээ авах боломж улам нээлттэй болж байна.

Цахим Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авах зорилгоор irgen.erdenet.mn цахим хуудсыг ажиллуулсны үр дүнд иргэд цахимаар төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл, гомдлоо илэрхийлэх боломжтой болсон.

Мөн түүнчлэн аймгийн иргэдэд төрийн байгууллагын 215 үйлчилгээг 24 цагийн турш авах боломжтой “Цахим төв”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсан нь төрийн үйлчилгээг нээлттэй авах боломжоор хангасан байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулж баталсан ч төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалын тодорхойлолтыг хянадаггүйгээс байгууллагын удирдлага албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагыг тодорхой тусгахгүй баталж байна.

Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийгээгүйгээс албан тушаалын давхардал, хийдлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийх нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор²¹ зохицуулагджээ.

Уг тогтоолын зорилго нь “Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарчим чиг үүргийг засаг захиргааны түвшин буюу тодорхой салбар хороонд эсхүл төрийн бус байгууллага, эсхүл хувийн хэвшилд шилжүүлэхэд” чиглэсэн байна.

²¹ Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал” батлах тухай.

Дээрх тогтоолын 6²²-д заасан чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг дарга байгуулаагүй, Төсвийн тухай хуулийн 14.2.11²³-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийгээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-н 3.1.2²⁴-д заасан чиг үүргийн шинжилгээ хийгдээгүй байна.

Аймгийн ЗДТГ-н бүтэц орон тооны дээд хязгаарыг хамгийн сүүлд Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаар тогтоох тухай” тогтоолоор 57 орон тоотой, Баян-Өндөр сумын ЗДТГ-н орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор 23 орон тоотой, Жаргалант сумын ЗДТГ-н орон тоог 16 байхаар тогтоосон байна.

Уг тогтоол нь орон тооны дээд хязгаарыг тогтоосон ч төрийн захиргааны албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн тусгай албан хаагч, улс төрийн албан хаагчийн тоог тодорхой тусгаж өгөөгүй байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тооны дээд хязгаарыг тогтоогоогүйгээс бүтэц орон тоо батлахдаа төрийн үйлчилгээний орон тоог нэмэгдүүлж, Төсвийн тухай хуулийн 16.5.3²⁵-д заасныг үндэслэн баталсан байна.

Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц орон тооны дээд хязгаарыг АЗДТГ-н даргын тушаалаар баталсан бүтэц орон тоотой харьцуулан дүрслэлээр харуулбал:

²² Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-н 6-д “Чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг /цаашид “ажлын хэсэг” гэх/ холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулна”

²³ Төсвийн тухай хуулийн 14.2.11-д “Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулна”

²⁴ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-н 3.1.2-д “Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар аргачлалын хүрээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх”


²⁵ Төсвийн тухай хуулийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажилчдын цалин хөлсийг тогтоох”

Дүрслэл №02 Аймгийн ЗДТГ-н бүтэц, орон тоо



Сумдын ЗДТГ-н бүтэц орон тоог Засгийн газрын баталсан орон тооны дээд хязгаартай харьцуулан дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №03



Дүрслэл №04



Дээрх дүрслэлээс харахад аймаг болон сумдын ЗДТГ-н бүтэц орон тоог Засгийн газрын баталсан дээд хязгаараас хэтрүүлэн баталсан нь төрийн үйлчилгээний орон тоог нэмж баталсантай холбоотой байна.

ЗДТГ-н баталсан орон тоог албан тушаалын ангиллаар харуулбал:

Хүснэгт №01

Сумдын нэр	Албан тушаалын ангилал	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Аймгийн ЗДТГ	УТ	2	2	2	2	2	2	2	3	3	2	2
	ТТ	3	3	4	4	4	4	4	4	4	4	4
	ТЗ	35	35	36	34	34	35	35	36	36	34	43
	ТҮ	34	34	33	24	28	27	27	25	25	26	20
	НИЙТ	71	71	71	64	68	68	68	68	68	66	69
Баян-Өндөр сумын ЗДТГ	УТ	3	3	2	2	2	2	2	2	2	2	2
	ТЗ	19	19	16	18	22	22	23	23	23	23	23
	ТҮ	23	23	30	28	24	24	27	27	27	27	27
НИЙТ		45	45	48	48	48	48	52	52	52	52	52
Жаргалант сумын ЗДТГ	УТ	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
	ТЗ	11	11	12	13	15	15	13	16	16	16	16
	ТҮ	13	14	15	17	19	29	29	32	32	31	31
НИЙТ		26	27	29	32	36	46	44	50	50	49	49

Эх сурвалж: Аймаг, сумдын ЗДТГ-н бүтэц орон тоо баталсан тушаал

Дээрх хүснэгтээс харахад жил тутамд төрийн үйлчилгээний орон тоог нэмэгдүүлж баталсан нь төрийн үйлчилгээний орон тооны хязгаарыг тогтоогоогүй, бүтэц орон тоонд хяналт хэрэгжүүлдэггүй, төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн албаны шалгалт өгдөггүй байгууллагын дарга шууд томилдог зэргээс шалтгаалсан байна.

Бүтэц орон тоонд чиг үүргийн шинжилгээ хийдэггүйгээс хэрэгцээ шаардлагагүй төрийн үйлчилгээний орон тоог нэмэгдүүлж, бүтэц орон тоо тогтворгүй, тогтолцоо оновчгүй байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагч нь бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал хийдлийг арилгах, иж бүрэн шинжилгээ хийж байх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөн аймаг сумдын бүтэц орон тооны дээд хязгаарыг тогтоохдоо албан тушаалын ангиллаар баталж байх, эрх зүйн орчныг сайжруулах тухай аудитын нэгдсэн тайланд тусгуулахаар санал уламжлав.

Аудитын судалгаанд хамрагдсан нийт 95 төрийн байгууллагын баталсан бүтэц орон тоог ажилласан албан хаагчийн тоотой харьцуулан харахад дараах байдалтай байна.

Хүснэгт №02

Он	Баталсан бүтэц орон тоо	Ажилласан албан хаагчийн тоо	Зөрүү
2013	3797	3846	49
2014	3785	3919	134
2015	3907	4022	116
2016	3974	4117	143
2017	4053	4129	76
2018	4157	4210	53
2019	4180	4250	70
2020	4241	4342	101
2021	4530	4509	-22
2022	4662	4650	-12
2023	4846	4817	-30
Нийт	41470	42161	691

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа. Дээрх тоон мэдээлэлд Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цэргийн ангийн нийт албан хаагчийн тоо ороогүй болно.

Дээрх хүснэгтээс харахад баталсан орон тооноос хэтрүүлэн ажилласан нь бүтэц орон тоо, зохион байгуулалтын боловсруулалтад дотоод хяналт хэрэгжүүлдэггүйтэй холбоотой байна.

Баталсан бүтэц орон тоонд хяналт хэрэгжүүлээгүйгээс төрийн захиргааны албан тушаалд төрийн үйлчилгээний албан тушаалтан томилсон, баталсан бүтэц орон тооноос хэтрүүлэн ажилласан зэрэг зөрчлүүд аудитын явцад илэрлээ. Тухайлбал:

- Хүнс, хөдөө аж ахуйн газар нь ХХААХҮСайдын баталсан бүтэц орон тоонд төрийн захиргааны албан тушаалтны орон тоо баталсан байтал дарга төрийн үйлчилгээний албан тушаалтан нэмж баталсан,
- Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын баталсан бүтэц орон тоо батлах тушаалд хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, дотоод аудиторын орон тоог батлаагүй байтал дарга нэмж баталсан,
- Стандартчилал хэмжил зүйн хэлтэс нь Стандартчилал хэмжил зүйн газраас баталсан бүтэц орон тооноос төрийн үйлчилгээний 2 орон тоог хэтрүүлэн ажилласан,
- Аймгийн ЗДТГ-н төрийн үйлчилгээний албан хаагчдыг оролцуулаад Засгийн газрын баталсан үндсэн орон тооноос 2013-2015 онд 31, 2016 онд 20, 2016-2021 онд 24, 2022 онд 6, 2023 онд 9 орон тоогоор илүү ажилласан,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь баталсан орон тооноос 2013 онд 4 орон тоо, 2014 онд 3 орон тоо, 2015 онд 2 орон тоо хэтрүүлэн ажилласан,

Байгууллагын дарга бүтэц орон тоо батлахдаа ижил ажил үүрэг гүйцэтгэх албан тушаалыг төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний гэж хоёр өөр ангиллаар баталж байна. Тухайлбал:

- АЗДТГ-н Санхүү төрийн сангийн мэргэжилтэн,
- Жаргалант болон Баян-өндөр сумын газрын даамал
- Нийгмийн даатгалын хэлтсийн сайн дурын даатгалын байцаагч


Мөн Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт”-д заасан төрийн захиргааны албан хаагчийн орон тоог төрийн үйлчилгээний орон тоогоор баталсан байна. Тухайлбал:

- Хотын захирагчийн албаны 6 мэргэжилтэн
- Баян-Өндөр болон Жаргалант сумын газрын даамал
- АЗДТГ-н НБХ-н ахмад настан, биеийн тамир спортын асуудал хариуцсан ажилтан
- АЗДТГ-н ХБХОТХ-н инноваци, бүтээмж, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах ажилтан, гадаадын зээл тусламж, харилцааны төсөл хөтөлбөр хариуцсан ажилтан, орон нутгийн хөгжлийн сан, чанарын менежментийн тогтолцоо стандарт хариуцсан ажилтан

Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор 2013-2023 онд төрийн 8 байгууллагад нийт 845 гэрээт ажилтныг ажиллуулж, орон нутгийн төсвөөс нийт 5,345,241.9 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна. [/Дэлгэрэнгүйг хавсралт №02/](#)

Гэрээтээр ажилласан албан хаагчийн тоо, олгосон цалинг харуулбал:

Дүрслэл №05



Эх сурвалж: Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлын тайлан

Дээрх дүрслэлээс харахад гэрээтээр ажилласан албан хаагчийн тоо болон олгосон цалин хөлс жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна.

Эдгээр гэрээт ажилтнууд нь төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхийн тулд иргэдэд үйлчилдэг бөгөөд тухайн төрийн байгууллагын үндсэн бүтэц орон тоонд батлагддаггүй байна.

Энэ нь төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан орон тоотой давхцал үүсэж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэж байна.

Иймд төрийн байгууллагын бүтэц орон тоонд шинжилгээ хийж, чиг үүргийн давхцалыг арилгах шаардлагатай байна.

Төрийн байгууллагын төрийн жинхэнэ удирдах болон гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа төрийн албаны төв байгууллагын баталсан нийтлэг журмыг баримталсан байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс нийт 21 байгууллагын 264 албан тушаалын тодорхойлолтыг хянаж, Төрийн албаны зөвлөлөөс “Зөвшөөрөл” авч тухайн байгууллагын даргаар баталгаажуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг албан тушаалын тодорхойлолтод тусгаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр хянуулан, Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авч дарга баталсан байна.

Харин төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлтийн салбар зөвлөлөөр хянуулдаггүйгээс албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын чиг үүрэгт тавигдах мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг тодорхой тусгахгүй дарга баталж байна. Тухайлбал:

- *Хот тохижуулах газрын албан тушаалын тодорхойлолт,*
- *Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн албан тушаалын тодорхойлолт,*
- *Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн албан тушаалын тодорхойлолт,*

Аудитаар түүвэрт хамрагдсан 28 байгууллагын 762 албан хаагчийн мэргэжил, мэргэшил, туршлага нь албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлд байгаа материал руу хөөн шалгахад 12 байгууллагын захиргааны болон үйлчилгээний 19 албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлагыг хангаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1/

Эдгээрийн зарим нь анх томилогдохдоо АТТ-ийн мэргэжлийн тусгай шаардлагыг хангаагүй, зарим нь АТТ-г шинэчлэн баталсантай холбоотойгоор хангаагүй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд зөвлөмж хүргүүлэв.

Холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоолоор тусгайлан зохицуулснаас бусад нийгмийн баталгаагаар тухайн байгууллагын онцлог, төсөв санхүүгийн боломжоос хамааран харилцан адилгүй хангагдаж байна.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны талаарх зохицуулалтууд Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж ирсэн.

Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, ажиллах нөхцөлөөр хангуулах, хууль бусаар төрийн албанаас чөлөөлөгдөх, халагдахгүй байх, ээлжийн амралт эдлэхээс авхуулаад төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэжил дээшлүүлэх, орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх зэрэг бүхий л зүйлсийг төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хүрээнд хамааруулж байна.

Иймд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах тогтолцоо нь төрийн албанд ажилтан сонгон шалгаруулж авахаас эхлээд төрийн албыг нэр төртэй хаших төрийн албан хаагчийн эрхийн хязгаарлалтын хүрээнд төрийн албан хаагчийн үндсэн эрх, ашиг сонирхлыг хангах, нийгэм-улс төр болон эдийн засгийн баталгаа, ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албанд үнэнч шударга ажиллах баталгааг хангах өргөн агуулгыг багтааж байна.

Байгууллагын зорилго, зорилтыг хангах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд ажилтнуудын мэдлэг чадвар, туршлага, зан төлөвийн асуудал чухал бол, тэдний ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэх, өөрийн мэдлэг чадвараа дайчлан ажиллахад нөлөөлөх зүйлсэд цалин хөлс, шагнал урамшуулал, тусламж дэмжлэг зэрэг нийгмийн баталгааны асуудал чухал нөлөө үзүүлдэг.

Шинэчлэн баталсан Төрийн албаны тухай хуулийн 55.3²⁶-д заасны дагуу бүх төрийн байгууллага ялангуяа захиргааны байгууллага албан хаагчдадаа зориулсан сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг ямар нэг байдлаар боловсруулж, байгууллагын төсөв, санхүүгийн боломжид тулгуурлан харилцан адилгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

²⁶ Төрийн албаны тухай хуулийн 55.3-д “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”

Дээрх хөтөлбөрөөс гадна нийгмийн баталгааны зохицуулалтуудыг салбарын хууль, тогтоомж, байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд тусган хэрэгжүүлж байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нөхөх төлбөр нь Засгийн газраас тогтоосон шатлал, зэрэглэл, сүлжээ, норм норматив, хувь хэмжээний хүрээнд нийтлэг зохицуулагдаж олгогдож байгаа бол буцалтгүй тусламж, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, орон байрны дэмжлэг туслалцаа авах тухайд төрийн албан хаагч ямар байгууллага, аль ангилалд ажиллаж байгаагаас хамааран хоорондоо эрс зөрүүтэй байгааг цаашид зайлшгүй анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал нутгийн захиргааны болон хүний тоо цөөнтэй, харьцангуй төсвийн боломжтой байгууллагын албан хаагчид төлбөртэйгөөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдаж байхад салбарын албан хаагчийн тоо ихтэй боловсролын салбарын албан хаагчид хааяадаа байгууллагынхаа төсвийн боломжид тулгуурлан өрхийн эрүүл мэндийн төв болон БОЭТ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн албан хаагчид салбарын хууль, тогтоомжоороо 3-5 жилд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авч байна.

Аймгийн ИТХ-аас баталсан Багш, Эмч дэд хөтөлбөрийн хүрээнд холбогдох салбарын албан хаагчдыг үзлэг шинжилгээ, сургалт, семинарт хамруулах, холбогдох дэмжлэгүүдийг олгож нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 61.2-т “Энэ хуулийн 61.1.5²⁷-д заасан баталгааг эдлүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан боловч энэхүү журам шинэчлэгдэн²⁸ батлагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийг баталж 2023 оноос хэрэгжүүлж байна. Мөн сумдын ЗДТГ²⁹-аас төрийн албан хаагчийн нийгмийн

²⁷ Төрийн албаны тухай хуулийн 61.1-д “Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана”, 61.1.5-д “орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх”

²⁸ Засгийн газрын 2007 оны 221 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдын орон сууц дэд хөтөлбөр батлах тухай”, 2009 оны 368 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журам”-ыг баталсан нь одоо ашиглагдахгүй ч хүчин төгөлдөр хэвээр байна.

²⁹ Баян-Өндөр сумын “Хэсгийн ахлагчдын хөгжлийн хөтөлбөр”, “Баян-Өндөр сумын ИТХ, ЗДТГ-ын төрийн албан хаагчдын хөгжлийн дэд хөтөлбөр”, Жаргалант сумын “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”.

баталгааг хангах зорилготой дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн холбогдох нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Дэлхийн банкнаас 2020 онд “Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж” судалгааны ажлаар төрийн албаны засаглалын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлага, цалин хөлсний удирдлага, ангилал, зэрэглэл ба цалин хөлс, урамшууллын тогтолцооны асуудлыг судалсан байна. Судалгааны тайланд одоо мөрдөж буй цалин хөлсний удирдлага, ангилал зэрэглэл болон цалин урамшуулал нь нарийн төвөгтэй, олон шатлалтай бөгөөд сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Эндээс харахад төрийн албан хаагчдын ажил үүргийн онцлог байдлыг харгалзан нийгмийн баталгааг тухайлан зохицуулах нь зүйтэй хэдий ч үндсэн төрийн албан хаагчийн баталгааг хангах суурь зохицуулалтаа харгалзаж үзэлгүй салбарын хууль бүрд харилцан уялдаа холбоо багатайгаар нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийж байгаа нь зохистой биш бөгөөд нийгмийн баталгааг хангахад төрийн нэгдсэн бодлого, нэгдмэл зарчмыг алдагдуулж тэгш бус байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Төрийн албаны хуулийн дагуу төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ч энэ нь шууд утгаараа төсөвтэй холбогдож, төсвөөс хамаарч хэрэгжих эсэх нь шийдэгддэг тул Төсвийн тухай хууль, бусад зохицуулалтуудтайгаа уялдаж өгөөгүй, албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлд яг ямар хэмжээтэй төсвийг зайлшгүй зарцуулах ёстой вэ гэдгийг нэгдсэн байдлаар хуульчилж, зохицуулж өгөөгүй байна.

Сул орон тооны томилгоог зарим тохиолдолд Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Төрийн захиргааны байгууллагуудын хувьд сул орон тоо гарсан тухай бүр хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт тусгай шалгалтын зар байршуулан, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, цахимаар бүртгүүлэх зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, аймгийн ЗДТГ-ын www.erdnet.mn цахим хуудас болон тухай байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлсэн байна.

Коронавирус халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлийн үед болон түүнээс өмнө ч сул орон тоог нийтэд нээлттэй зарлан мэдээлэхгүйгээр төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлгүй, сонгон шалгаруулалтгүйгээр, хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг томилсон тохиолдол гарсаар байна.

Дээрх зөрчлүүдийг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоол, 2023 онд явагдсан Монгол Улсын Засгийн газрын “Шүүр” ажиллагаа, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 332 дугаар тогтоолын хүрээнд арилгасан боловч дараах зөрчлүүд одоог хүртэл байсаар байна. Үүнд:

- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн нь Англи-Орос хэлний орчуулагч инженер мэргэжилтэй, Боловсрол судлалын магистр зэрэгтэй одоогийн эрхэлж буй ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод заасан /Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, менежмент ба удирдахуй/ мэргэжлийн тусгай шаардлага хангахгүй, ТЖАХ-н албан тушаалд хуулийн дагуу томилогдоогүй ч одоог хүртэл ажиллаж байна.

Хүснэгт № 03 ЭМГ-ийн мэргэжилтний албан тушаалын томилгоотой холбоотой шийдвэрүүдийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Огноо	ТЖАХ-н шалгалт, томилгоотой холбоотой шийдвэр
1	2016.06.06	Булган аймагт Хануй голын сав газрын захиргааны Сургалт, олон нийт төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалд ТЖАХ-ийн шалгалт өгч тэнцэн нөөцөд бүртгэгдсэн.
2	2016.10.24	Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн Б/82 дугаар тушаалаар тус газрын Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, сургалт хариуцсан мэргэжилтнийг хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ТҮ-7.1 шатлалаар түр томилсон.
3	2017.06.23	Түр ажлын байранд ТЖАХ-ийн тангараг өргүүлэхээр ЭМГ-ийн даргын Б/31 дугаартай тушаал гарсан.
4	2017.08.14	Боловсролын байгууллагад ажиллах болсон тул ЭМГ-н даргын Б/34 дүгээр тушаалаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн
5	2017.09.06	Түр ажлын байрнаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөний дараа ажилгүй байх хугацаандаа ТЖАХ-н тангараг өргөсөн.
6	2017.10.25	ЭМГ-н даргын үүрэг гүйцэтгэгчийн Б/46 дугаар тушаалаар буцаан хүний нөөцийн хангалт, төлөвлөлт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ТЗ-5-1-р томилсон.
7	2018.05.15	ЭМГ-ийн даргын Б/27 дугаар тушаалаар ЭМГ-н удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчээр түр томилсон. Томилгоотой холбоотой АТГ-н бичиг авахаар /ХАСУМ/ 2018.05.31-ний өдөр 1/487 дугаар албан бичиг хүргүүлж, АТГ-н хариу бичиг 2018.06.18-нд ирсэн. Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, сургалт хариуцсан мэргэжилтэн болсон.
8	2018.10.01	ЭМГ-н удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул уг албан тушаалын сул орон тоонд шилжин ажиллах хүсэлт гаргасны дагуу ЭМГ-н даргын Б/46 дугаар тушаалаар удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтнээр томилсон.

- Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар тус газрын Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтнээр томилогдсон иргэн нь Био анагаах, дархлаа судлаач мэргэжилтэй бөгөөд албан тушаалын тодорхойлолтод заасан “Эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэнд судлаач” гэж заасан мэргэжлийн тусгай шаардлагыг хангахгүй байна.
- Орхон аймгийн ЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нь анх туслах түшмэл ТЗ-3 албан тушаалын ангилалд /Жаргалант сумын ЗДТГ-н дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ ТЖАХ-н мэргэжлийн шалгалт өгч тэнцээд тухайн албан тушаалдаа нэр дэвшиж томилогдсон өдрөө буюу Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхлэхийн өмнөх өдөр /2018.12.31/ шилжүүлэх, томилох бүх тушаалуудыг гаргаж, өөр байгууллагад дэс түшмэлийн албан тушаалд шилжин томилогдсон байна.

Хүснэгт № 04 АЗДТГ-н ахлах мэргэжилтний албан тушаалын томилгоотой холбоотой шийдвэрүүдийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Огноо	ТЖАХ-н шалгалт, томилгоотой холбоотой шийдвэр
1	2018.12.24	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн /ТЗ-3/ туслах түшмэлийн орон тоонд ТЖАХ-ийн мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн.
2	2018.12.28	Төрийн албаны зөвлөлийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 207 дугаар тогтоолоор туслах түшмэлийн нөөцөд бүртгэн, тухайн албан тушаалд нэр дэвшүүлсэн байна.
3	2018.12.31	Орхон аймаг дахь Салбар зөвлөлийн 85 дугаар албан бичгээр 207 тогтоолыг Жаргалант ЗДТГ-н даргад хүргүүлсэн.
4	2018.12.31	Жаргалант сумын ЗДТГ-н даргын Б/48 дугаар тушаалаар Дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
6	2018.12.31	Жаргалант сумын ЗДТГ-н даргын Б/57 дугаар тушаалаар Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албанд шилжүүлсэн.
7	2018.12.31	Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албаны Захиргаа, санхүүгийн албаны дарга, эрх, хүний нөөц хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар аймаг дахь ТАЗ-ийн салбар зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар нэр дэвшүүлэх дүгнэлт гаргасан. /Дэс түшмэл/ Жич: Эх хувийг аудитад ирүүлээгүй.
8	2018.12.31	Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын даргын Б/05 дугаар тушаалаар тус газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга, эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтнээр /дэс түшмэл/ томилсон.

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нь төрийн захиргааны албан тушаалд төрийн үйлчилгээний ангиллаар 2018 оноос хойш одоог хүртэл ажиллуулж байна. /Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/6/14 дүгээр тушаалаар анх томилсон/.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 16-ны тушаалын 16 дугаар хэсгээр баталсан

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: _____

Дагаж мөрдөх огноо: _____

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: _____

Байгууллагын нэр: _____

Нэгжийн нэр: _____

Аймгийн даатгалын хэлтэс: _____

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг: _____

Албан тушаалын нэр: _____

Албан тушаалын ангилал, зэрэглэл: _____

Магадлагч эмч, тэтгэмжийн хяналтын байцаагч: _____

Дэс түшмэл, ТЗ-6: _____

Ажлын цаг: _____

Ажлын байрны албан ёсны байршил: _____

Ажлын өдрийн 8 цаг: _____

Хөдөлмөрийн нөхцөл: _____

Онцгой нөхцөл: _____

Хэвийн: _____

Хамаарахгүй: _____

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Магадлагч эмчийн албан тушаалын тодорхойлолтыг 2016, 2020 онд ТЗ-6 дэс түшмэлээр баталсан.

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 214 дүгээр тогтоолын 18 дугаар хэсгээр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: _____

Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) 2023-07-07

Дагаж мөрдөх огноо: _____

2024.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: _____

Байгууллагын нэр: _____

Нэгжийн нэр: _____

Аймгийн даатгалын газар: _____

Нийгмийн даатгалын газар: _____

Албан тушаалын нэр: _____

Албан тушаалын ангилал, зэрэглэл: _____

Магадлагч эмч мэргэжилтэн: _____

Дэс түшмэл, ТЗ-9: _____

Ажлын цаг: _____

Ажлын байрны албан ёсны байршил: _____

Ажлын өдрийн 8 цаг: _____

Хөдөлмөрийн нөхцөл: _____

Онцгой нөхцөл: _____

Хэвийн: _____

Хамаарахгүй: _____

ТАЗ-ийн 2024 оны 214 дүгээр тогтоолын 18 дугаар хэсгээр Нийгмийн даатгалын газрын Магадлагч эмч мэргэжилтний албан тушаалын ангилал, зэрэглэлийг ТЗ-6-р хянаж, зөвшөөрөл олгосон.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 3 сарын 29-ны өдөр

Дугаар А/39

Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.9, Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хэсгээр баталсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны "Бүтэц, орон тоо батлах тухай" А/22 дугаар тушаалын 6 дугаар хэсгээр баталсан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн орон тоо, албан тушаалын жагсаалтад "Сүлжээний инженер", "Сан хариуцсан мэргэжилтэн" гэсэн албан тушаалын нэршилгүй шинээр нэмж, "Магадлагч эмч, тэтгэмжийн хяналтын байцаагч" гэсэн албан тушаалыг "Магадлагч эмч" гэж өөрчилсүгэй.
- Шинээр нэмсэн болон өөрчлөлт оруулсан сүлжээний инженер, сангийн нягтлан бодогч, магадлагч эмчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, мөрдөн ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /Газар/-ийн дарга нарт зөвшөөрсүгэй.
- Батлагдсан орон тооны хязгаарт багтаан, тухайн албан тушаалын тодорхойлолтод завсан шаардлага хангасан иргэний томион ажиллуулахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /Газар/-ийн дарга нарт үүрэг болгосугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Батсүх/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар бүтэцлөх дугаар А/39

ХУУЛЬСАР ҮНДЭН

Ц.ГАНЦЦЭГ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга

НДЕГ-н даргын 2023 оны А/39 дүгээр тушаалаар магадлагч эмчийг ТҮ-ийн албан тушаал байж болох талаар зохицуулсан тухай 2023.03.29-ний өдрийн 02/618 дугаар албан бичгийг аймгийн НДГ-т ирүүлсэн.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/27 тушаалын 21 дүгээр хэсгээр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: _____

Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) 2023-07-07

Дагаж мөрдөх огноо: _____

2024.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: _____

2024.06.19

Байгууллагын нэр: _____

Нэгжийн нэр: _____

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар: _____

Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс: _____

Албан тушаалын нэр: _____

Албан тушаалын ангилал, зэрэглэл: _____

Магадлагч эмч: _____

ТҮ-6: _____

Ажлын цаг: _____

Ажлын байрны албан ёсны байршил: _____

Ажлын өдрийн 8 цаг: _____

Хөдөлмөрийн нөхцөл: _____

Онцгой нөхцөл: _____

Хэвийн: _____

Хамаарахгүй: _____

Орхон аймгийн НДГ-н даргын 2024.06.19-ний өдрийн А/27 дугаар тушаалын 21 дүгээр хэсгээр ТАЗ-ийн 218-р тогтоолоор баталсан магадлагч эмч мэргэжилтний ТЗ-6 албан тушаалыг ТҮ-6 болгож нүүрийг сольж баталсан.

Дээрх албан хаагчдын зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Гүйцэтгэлийн аудитын явцад 28 байгууллагын 762 албан хаагчийн хувийн хэргийг түүвэрлэн үзэхэд Төрийн үйлчилгээний албан хаагчийг төрийн захиргааны алба хаагчаар цалинжуулсан зөрчил мөн илэрсэн. Үүнд:

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Б/91 дүгээр тушаалаар иргэнийг ЗДТГ-ын жолоочоор томилсон бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/144 дүгээр тушаалаар хүүхэд асрах чөлөөтэй Хот төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний оронд ТАТХ-ыг зөрчин нөөцөд бүртгэлгүй төрийн үйлчилгээний албан хаагчийг түр томилон ажиллуулж байгаад 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс Б/320 дугаар тушаалаар буцаан ЗДТГ-ын газрын жолоочоор ТАТХ-ын 22.1-г үндэслэн томилсон боловч Хот төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг гүйцэтгүүлсэн байна.

Мөн түүнчлэн төрийн захиргааны албан тушаалд төрийн үйлчилгээний албан хаагчаар томилон, тухайн томилогдсон албан хаагч төрийн албаны шалгалт өгч тэнцсэн үед төрийн жинхэнэ албан хаагчаар томилон тангараг өргүүлсэн зөрчил удаа дараа гаргасан байна. Үүнд:

- Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын /2018.04.24-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар бий болсон/ албаны дотоод аудиторын сул орон тоог ТА3-д хүсэлт өгч сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй, нөөцөд бүртгэлгүй иргэнийг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар дотоод аудитораар ТҮ-7.1 зэрэглэлээр томилсон байна. Тухайн иргэн нь 2018 оны 09 дүгээр сарын 27-нд Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Эрүүл мэндийн даатгалын орлого шимтгэлийн даатгалын байцаагчийн ТЖАХ-ийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдээд Орхон аймаг дахь ТА3-ийн салбар зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор тус албан тушаалд нэр дэвшүүлж, албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/13 дугаар тушаалаар томилсон.
- Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/15 дугаар тушаалаар нөөцөд бүртгэлгүй иргэнийг Баян-Өндөр сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчээр ТҮ-5.1-р шатлалаар томилсон бөгөөд 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар тусгай шалгалтгүйгээр улсын байцаагчаар түр томилж, тусгай шалгалт өгч тэнцсэн тул 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар жинхлэн томилсон байна.
- Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/15 дугаар

тушаалаар нөөцөд бүртгэлгүй иргэнийг Шимэгчлэх, халдваргүй өвчин, эм био бэлдмэлийн асуудал, өвчний мэдээ хариуцсан мэргэжилтнээр ТҮ-р томилж, 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар чөлөөлж, тусгай шалгалт өгч тэнцсэн тул 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар жинхэлсэн байна.

- Сэлэнгэ голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнийг тус захиргааны даргын 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар гадаргын усны нөөц хариуцсан ахлах мэргэжилтнээр ТҮ-8.1 шатлалд хамруулан томилсон бөгөөд тухай үед төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэлгүй байсан ба 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 27 дугаар тушаалаар Газрын доорх усны нөөц хариуцсан ахлах мэргэжилтнээр мөн ТҮ-р томилсон. 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр төрийн албан хаагчийн шалгалт өгч, 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 32 дугаар тушаалаар Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалт хариуцсан мэргэжилтнээр жинхэлсэн байна.
- Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/42 дугаар, 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Б/44 дүгээр тушаалаар төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй 2 иргэнийг төрийн захиргааны албан тушаалд ТҮЭМ-5 зэрэглэлээр томилсон бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/25, Б/26 дугаар тушаалуудаар жинхлэн томилсон.

Төрд хохирол учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил” ажиллагааг хэрэгжүүлсэн байна.


Авлигатай тэмцэх газраас “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлж хууль бус томилгоо, хуульд заасан шаардлага хангаагүй албан хаагчдыг албан тушаалаас нь чөлөөлөх ажиллагааг хэрэгжүүлжээ. Тус ажиллагаа нь 2023 онд хийгдсэн бөгөөд аймгийн хэмжээнд нийт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 24 албан хаагч шүүр ажиллагаанд хамрагдаж ажлаас чөлөөлжээ.

Харин төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж ажлаас чөлөөлсөн тухай тушаал шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн томилогдох, ажилгүй байсан хугацааны цалин, НДШ нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргуулдаг байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2013-2023 онд хөдөлмөрийн маргаантай холбоотой давхардсан тоогоор нийт 810 нэхэмжлэл хүлээн авч, 526 нэхэмжлэлийг тухайн ондоо шийдвэрлэсэн байна. Үүнээс 137 албан хаагчийг албан тушаалд нь эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн нөхөн төлбөрт нийт 249,132.4 мянган төгрөгийг нэхэмжлэгч талд гаргуулах шийдвэр гарсан байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ТАХ-н эрх зөрчигдөж нэхэмжлэл гаргасан нэхэмжлэлийн тоон үзүүлэлтийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл № 06



Эх сурвалж: Орхон аймаг дахь Шүүхийн Тамгын газар

Дээрх дүрслэлээс харахад ТАХ-н эрх зөрчигдөж шүүхэд нэхэмжлэл гаргасан тоон үзүүлэлт 2020 оноос хойш буурсан нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйл болон Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтөөр төрд учруулсан хохирлыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр хуульчилж өгсөнтэй холбоотой байна.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр 2013-2023 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт давхардсан тоогоор нийт 42 албан хаагч 278,200.8 мянган төгрөгийн төлбөр төлүүлэхээр хандсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж дээрх төлбөрийг хариуцагч байгууллагаар 40 албан хаагчийн 268,290.1 мянган төгрөгийг бүрэн төлүүлж, 2 албан хаагчийн 9,910.7 мянган төгрөгийг төлүүлэхээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэрэгжүүлж байна.

Харин буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай аймгийн Прокурорын газраас 2022-2023 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 46,324.1 мянган төгрөгийн 3 нэхэмжлэл гаргасан боловч шүүх нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан шалтгаанаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны тухай хулийн 50.2³⁰-д заасны дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах зохицуулалттай. Иймд 2013-2023 онд төрд учруулсан хохирлын бүртгэл хөтөлж, нөхөн төлөлтөд хяналт хэрэгжүүлж, төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах талаар нэгдсэн тайланд тусгуулах саналыг уламжлахаар шийдвэрлэв.

Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл зөрүүтэй, 2020 оноос өмнөх үеийн нэгдсэн тоон мэдээллийн эх сурвалж хангалтгүй байна.

Орхон аймгийн төрийн албан хаагчийн 2023 оны тоо бүртгэлээс үзвэл төрийн 95 байгууллагад 5007 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2013 онтой харьцуулахад 1,256 албан хаагчаар буюу 33.5 хувиар өссөн байна.

Нийт төрийн албан хаагчийн тоо 2013 онд аймгийн нийт хүн амын 4 хувь, идэвхтэй хүн амын 9.5 хувь, ажил эрхэлж байгаа хүн амын 12.1 хувийг тус тус эзэлж байсан бол 2023 оны байдлаар төрийн албан хаагчийн тоо нийт хүн амын 4.5 хувь, идэвхтэй хүн амын 14.8 хувь, ажил эрхэлж байгаа хүн амын 16.1 хувийг тус тус эзэлж байна. Үүний шалтгаан нь аймгийн хүн ам 2023 онд 2013 онтой харьцуулахад 18 хувиар өссөн боловч идэвхтэй хүн амын 14.5 хувиар буурсан, ажил эрхэлж байгаа хүний тоо 0.2 хувиар буурсантай холбоотой байна.

Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо мэдээлэл ТА3-с бүх шатны төрийн байгууллагуудад нэвтрүүлээд буй “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-с илүү дэлгэрэнгүй нарийвчлалтай гарч байгаа бөгөөд 2020 оноос өмнөх үеийн нэгдсэн тоо, бүртгэл, судалгаа хангалтгүй байна. Аймгийн төрийн байгууллагуудаас 2013-2023 онуудыг хамарсан нэгдэн судалгаа авч, нэгтгэхэд батлагдсан орон тоо, гүйцэтгэлээр ажилласан албан хаагчдын тоо зөрүүтэй бөгөөд ТА3-н Салбар зөвлөлд ТАХ-ын нэгдсэн тоо бүртгэлийн судалгаа хангалтгүй байна.

Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмыг шинэчлэн, боловсронгуй, тодорхой болгох шаардлагатай байна.

³⁰ Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана

Төрийн албаны тухай хуулийн 16.1-д “Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа, эрхэлж байсан мэдээлэл болон энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг тусгасан байна” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам, загвар батлах тухай” тогтоолын 2.1.1, 2.1.4, 2.1.5, 2.1.6-д заасан нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг харьяалах Салбар зөвлөл хөтлөх бөгөөд 2023 оны байдлаар Орхон аймгийн салбар зөвлөлийн нөөцөд нийт 553 төрийн жинхэнэ албан хаагч бүртгэлтэй байна.

Хүснэгт № 05 Нөөцөд бүртгэлтэй албан хаагчийн судалгаа

№	Заалтын дугаар	Заалт	Нөөцөд бүртгэлтэй албан хаагч				
			2019	2020	2021	2022	2023
1	2.1.1	төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөц	503	478	507	522	528
2	2.1.4	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц	7	10	12	18	20
3	2.1.5	Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээд офицер, офицер, ахлагч/төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц	0	1	1	2	5
4	2.1.6	эрх бүхий байгууллагын шийдвэрээр нөхөр /эхнэр/ нь өөр орон нутаг, гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон, эсхүл гэр бүлийн хүнд өвчтэй аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц	0	0	0	0	0
НИЙТ ДҮН			510	489	520	542	553

Эх сурвалж: Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан

Дээрх журмын 2.1.4-н нөөцийн бүртгэлтэй холбоотойгоор дараах тодорхойгүй байдал үүссэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар Солонгос улсад магистрын зэрэг горилон суралцах болсон шалтгаанаар түр чөлөөлөгдсөн иргэн нь 2015.10 сараас 2021.12 сар хүртэл төрийн албаны нөөцөд бүртгэлтэй байсан. Тухайн иргэн 2021 оны 12 сарын 15-нд тусгай шалгалт өгч 2021 оны 12 сарын 17-ний өдрийн Б/57 дугаар тушаалаар буцаан ажилдаа томилогдсон байна. Тус албан хаагч нь дээрх хугацаанд магистрт хэрхэн суралцсан нь тодорхойгүй,

харин 2021.02.09-2021.03.22-ний хооронд Солонгос улсад сургалтад хамрагдаж сертификат авсан баримтаа бүрдүүлсэн байна.

- Орхон аймгийн ЗДТГ-н даргын 2017 оны 01 дүгээр сарын 17-ний Б/14 дугаар тушаалаар гурван сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон шалтгаанаар төрийн албанаас түр чөлөөлсөн иргэн нь нөөцөд бүртгэгдэж, Орхон аймгийн ГХБХБГ-н даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулан нэр дэвшүүлэх хүртэл хугацаанд томилогдож, ГХБХБГ-т тусгай шалгалт өгч жинхэлсэн байна. 2017.01 сараас 2020.01 сар хүртэл хэрхэн суралцсан нь тодорхойгүй, 2017 оны 05-р сард АНУ-д англи хэлний курс төгссөн сертификат авсан баримт бүрдүүлсэн байна.

Иймд дээрх журмын 2.1.4-д заасан нөөц буюу Төрийн албаны тухай хуулийн 46.1.1, 46.1.2-д заасан 3 сараас дээш хугацаагаар эмчлүүлэх болон 6 сараас дээш хугацаагаар суралцах шалтгаанаар төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийг нөөцөд байх хугацааны нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх талаар энэхүү журамд тодорхой тусгах шаардлагатай байна.

Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлд тавих хяналт үр дүнтэй хэрэгжихгүй байна.

Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо мэдээлэл, бүртгэл, статистик үзүүлэлтийн хүртээмж чанар “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем” нэвтэрч эхэлснээс хойш буюу 2020 оноос эхлэн эрс сайжирсан бөгөөд илүү олон төрлийн мэдээллийг бага цаг хугацаанд авах боломжтой болсон. Харин аймгийн Салбар зөвлөлийн хувьд дээрх мэдээллийг харах, нэвтрэх тусгайлсан эрхгүй, тухайн системийн хугацааны нарийвчлалтай нэгдсэн мэдээлэл авах боломж хязгаарлагдмал нь тус системийг илүү боловсронгуй болгох шаардлагатайг илтгэж байна.

Аймгийн салбар зөвлөлд 2019 оноос өмнөх үеийн нэгдсэн тоо бүртгэл, мэдээлэл хомс байдаг нь 1-т Хүний нөөцийн мэргэжилтэн өөрчлөгдөхөд хангалттай тайлан мэдээ, судалгааг архивлаж үлдээгээгүй, 2-т Төрийн албаны хүний нөөцийн хуучин системийн ашиглалт хангалтгүй, тайлан мэдээ нэгтгэх боломжгүй байсантай холбоотой байна.

Цаашид “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-ийг улам боловсронгуй болгож, албан хаагчийн боловсролын бичиг баримт болон мэргэшүүлэх курс төгссөн байдал, цэргийн албан хаасан байдал зэрэг мэдээллийг ХУР системээс татдаг байх, тухайн байгууллагын хүний нөөцтэй холбоотой тайлан мэдээллийг цаг хугацааны давтамжаар татаж авах боломжтой байх, аймгийн Салбар зөвлөл тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын хүний нөөцийн

мэдээллийг нэгтгэн харах, албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн бүртгэл хийгдсэний дараа харьяалах ТАЗ-ын салбар зөвлөлд мэдээлэл очдог байх зэрэг хяналт тавих боломжтой хөгжүүлэлтийг хийх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан цахим болон танхимаар сургаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтыг Удирдлагын академи хариуцан зохион байгуулж байна.

Мэргэшүүлэх багц сургалтаар төрийн албан хаагчийн богино болон дунд сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх богино хугацааны сургалтад, төрийн захиргааны албан хаагчдыг тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангиллаар цахим болон тахимын сургалтад хамруулж байна.

Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг сүүлийн 5 жилээр харуулбал:

Хүснэгт № 06

Он	Богино хугацааны сургалт	Анх томилогдсон чиглүүлэх сургалт	Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Ахлах түшмэл	Эрхэлсэн түшмэл
2019	125	-	-	-	-
2020	115	8	41	27	2
2021	51	16	17	6	2
2022	44	26	54	9	2
2023	224	14	16	13	2
Нийт	559	64	128	55	8

Эх сурвалж: Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад нийт 814 албан хаагчийг Удирдлагын академийн сургалтад цахим болон танхимаар хамруулж, төрийн албан хаагчийг мэргэшүүлсэн байна.

Мөн удирдлагын академийн магистрын “улирлын” сургалтад 2019-2023 онд нийт 6 албан хаагч хамрагдаж, орон нутгийн төсвөөс 11,156.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Сургалтын хөтөлбөр, элсэлтийн тухай мэдээллийн зарыг erdenet.mn цахим сайтад байршуулж олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн байна.

Төрийн албан хаагчдын сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс болон байгууллагын төсвөөс санхүүжилтийг олгож байна.

Төрийн албаны тухай хуулийн 55.3-д “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу төрийн байгууллагууд сургалтын төлөвлөгөө баталж, албан хаагчдаа сургалтад хамруулдаг байна.

Төрийн байгууллагаас авсан судалгаанаас харахад давхардсан тоогоор 10397 албан хаагч 511,770.6 мянган төгрөгийн зардлаар дотоод сургалтад, 50 албан хаагч 75,027.7 мянган төгрөгийн гадаад сургалтад хамрагджээ.

Хүснэгт №07 Сургалтад хамрагдсан мэдээлэл

Он	Дотоод сургалт		Гадаад сургалт	
	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн /мян. төг/	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн /сая. төг/
2013 он	774	9,375.0	1	-
2014 он	541	10,855.8	3	200.0
2015 он	459	9,028.2	-	-
2016 он	481	11,188.2	1	-
2017 он	606	10,934.1	2	3,060.0
2018 он	600	14,775.0	-	-
2019 он	778	40,194.3	14	12,054.7
2020 он	773	54,383.0	1	-
2021 он	1254	89,115.05	1	-
2022 он	1858	111,064.7	1	-
2023 он	2273	150,857.3	26	59,713.0
Нийт	10397	511,770.6	50	75,027.7

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

2021-2023 онд нийт 459 төрийн албан хаагчийг сургалтад хамруулж, орон нутгийн төсвөөс 24,076.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төрийн албан хаагч шаардлагатай сургалтад бүрэн хамрагдаж байна.

Жил бүр Удирдлагын академиас суралцах албан хаагчдын тоог тогтоож аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлдэг байна.

Удирдлагын академийн сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь төрийн байгууллагуудаас авч нэгтгэж, эрэмбэлэн Удирдлагын академийн сургалтад хамруулж байна.

Удирдлагын академиас ирүүлсэн сургалтын тооны хязгаарыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №08 Сургалтын тооны хязгаар

Он	Богино хугацааны сургалт	Анх томилогдсон чиглүүлэх сургалт	Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Ахлах түшмэл	Эрхэлсэн түшмэл
2019 он	45	-	-	-	-
2020 он	7	8	41	27	2
2021 он	42	16	17	5	2
2022 он	44	26	54	9	2
2023 он	12	14	16	8	2
Нийт	141	64	128	49	8

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан

Дээрх хүснэгтийг сургалтад хамрагдсан албан хаагчтай харьцуулахад богино хугацааны сургалт болон ахлах түшмэлийн сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо Удирдлагын академиас ирүүлсэн тооны хязгаараас их байгаа нь албан хаагчид хувиараа сургалтад хамрагдаж, төгссөнтэй холбоотой байна.

Удирдлагын академийн сургалтад хамрагдах шаардлагатай нийт 64 албан хаагч байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон зохицуулалтын хүрээнд шилжүүлэн ажиллуулсан байна.


Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, хэрэгцээ шаардлага, тухайн албан хаагчийн хүсэл сонирхолд тулгуурлан Төрийн албаны тухай хуулийн хүрээнд шилжүүлсэн ажиллуулсан байна.

Аудитын хүрээнд авсан нэгдсэн судалгааны маягтаар хүлээн авсан сэлгэн болон шилжүүлэн ажилласан талаарх тоон мэдээллээр 2013-2023 оны хооронд нийт 192 албан хаагчийг төрийн байгууллага хооронд сэлгэн, шилжүүлэн ажиллуулсан байна.

Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна.

2023 оны байдлаар Орхон аймгийн Төрийн албан хаагчдын дийлэнх буюу 74.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь улсын дунджаас даруй 10.6 хувиар илүү байна.

Дүрслэл № 07



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас анхдагч мэдээллийг ашиглан тооцоолов.

Төрийн албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 2016 онтой харьцуулахад 2023 оны байдлаар 23 хувиар өссөн ба эсрэгээр эрэгтэйчүүдийн эзлэх хувь 2023 онд 2 хувиар өссөн боловч 2020, 2021, 2022 онуудад 19 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлын үед эрэгтэйчүүд төрийн албанаас ихээр чөлөөлөгдсөнтэй холбоотой байна.

Хүснэгт №09

Он	Эрэгтэй			Эмэгтэй			Бүгд	
	Тоо	Эзлэх хувь	Өсөлт/бууралт	Тоо	Эзлэх хувь	Өсөлт/бууралт	Тоо	Өсөлт/бууралт
2016	1,265	29%	0%	3,035	71%	0%	4,300	0%
2017	1,313	30%	4%	3,067	70%	1%	4,380	2%
2018	1,147	27%	-9%	3,077	73%	1%	4,224	-2%
2019	1,321	30%	4%	3,102	70%	2%	4,423	3%
2020	1,025	24%	-19%	3,216	76%	6%	4,241	-1%
2021	1,029	24%	-19%	3,290	76%	8%	4,319	0%
2022	1,022	22%	-19%	3,714	78%	22%	4,736	10%
2023	1,286	26%	2%	3,721	74%	23%	5,007	16%

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас анхдагч мэдээллийг ашиглан тооцоолов.


Төрийн албаны албан тушаалын ангиллаар 2021-2023 оны хоорондох мэдээллийг авч үзвэл, төрийн улс төрийн албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс цөөн байна. Орхон аймгийн төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн тоо судалгаанд нууцын зэрэглэлтэй төрийн тусгай албан хаагчдын тоо /Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд/ ордоггүй бөгөөд эдгээр байгууллагуудад эрэгтэй албан хаагчид илүүтэй алба хаадаг нь төрийн тусгай албан хаагчдын хүйсийн харьцаа судалгаанаас зөрүүтэй гарч байна.

Төрийн алба хааж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өссөн байна.

Орхон аймагт 2023 оны байдлаар нийт 4,582 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оршин суудгийн 2,599 буюу 57 хувь нь эрэгтэй, 1983 буюу 43 хувь нь эмэгтэй байна.


Энэ нь аймгийн нийт хүн амтай харьцуулахад 4.1 хувийг эзэлж байгаа бөгөөд уг үзүүлэлт 2013 оны байдлаар 3.7 хувьтай байсан нь ХБИ-н хүн амд эзлэх хувь харьцангуй тогтвортой байгаа бөгөөд харин нийт ХБИ-ийн дунд эзлэх төрийн албан хаагч ХБИ-н хувь, нийт төрийн хаагчдын дунд эзлэх ХБИ-ийн тоо 2013 оноос хойш тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл № 08 ХБИ-н эзлэх хувийн жингийн диаграмм



Дүрслэл №09

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна”, 144.3-д “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө” гэж заасны дагуу 2013-2023 онуудад Орхон аймгийн хэмжээнд 157,453.6 мянган төгрөгийн төлбөр



төвлөрүүлэхээс нийт 4,603.2 мянган төгрөгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн байна. Төлбөр төлөлт хангалтгүй байгаа шалгаан нь төлбөрийг төвлөрүүлэх эргэх холбоо хангалттай ажиллахгүй байгаатай холбоотой.

Төрийн байгууллагын цахимаар үзүүлж буй үйлчилгээг иргэд хүлээн авах боломж, бололцоог олгох талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолоор “Цахим Эрдэнэт - 1” хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх Мастер төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар батлуулан ажлын хэсэг байгуулагдан 2023 оны байдлаар Смарт Эрдэнэт платформ, аймаг болон сумдын веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн түргэний үйлчилгээнд ухаалаг таблет, багийн төвүүдэд ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, Цахим Эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо, гадаад гарц, дугаар илрүүлэгчтэй камер зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, аймгийн төвд бусад аймгуудаас анх удаа 2021 онд E-Mongolia төвийг байгуулж, улмаар 2 суманд E-Mongolia төвийг байгуулан үйлчилгээний ажилтнуудыг сургаж, ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшсэн байна.

Мөн аймгийн ЗДТГ нь дэргэдээ 24 цагийн үйлчилгээ бүхий “Цахим төв”-ийг нээн ажиллуулж, Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаар 16 төрлийн 37 үйлчилгээ, E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн ХҮР – ДАН системээс иргэн, хуулийн этгээдийн 73 төрлийн үйлчилгээг, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаар 9 төрлийн 72 үйлчилгээ, ХААН болон Төрийн банкны АТМ, киоск машинаар төрийн үйлчилгээ, үүрэн холбоо, авто тээвэр гэх мэт 5 төрлийн 33 үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэн үйлчилж байна. 2023 оны байдлаар Цахим төвөөр 7500 гаруй ирэн үйлчлүүлж, цахим үйлчилгээ авсан байна.

Төрийн сангийн төлбөр тооцоог цахим системд шилжүүлэх зорилт амжилттай хэрэгжиж 2023.01.01-ээс эхлэн нууцад хамаарах байгууллагуудаас бусад бүх байгууллагууд Төрийн сангийн удирдлагын цахим системээр /портал/ төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Цахим шилжилтийн бэлтгэл ажил болгон 102 байгууллагын 214 ажилтанд сургалт хийж, шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр ханган, Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын нэг цонхны байранд Төрийн үйлчилгээний цэг байгуулсан байна.

Газрын харилцааны цахим шилжилтийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор 2 ширхэг үйлчилгээний киоск төхөөрөмж буюу e-gazag цахим системийн өөртөө үйлчлэх ухаалаг төхөөрөмжийг ажиллуулж байна. Тус киоск төхөөрөмж нэвтэрснээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд газар эзэмших,

ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв хянан баталгааны дүгнэлт, газрын барьцаа, төлбөрийн мэдээлэл зэрэг 18 төрлийн үйлчилгээг хурдан хугацаанд авах боломжийг бүрдүүлсэн байна.

Дотоод удирдлагын программ хангамж болох И-Оффис системийг 2018 оны 5 сараас нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, орон нутгийн төрийн байгууллагууд, эмнэлэг сургууль, цэцэрлэгүүдийг хамарсан 154 байгууллага, тэдгээрийн 1675 хэрэглэгч албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болгон холбосон байна.

Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, Засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий 7 үндсэн систем 30-аад төрлийн дэд систем ажиллаж байна.

Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн явц хэрхэн явагдаж байгааг иргэдэд ил тод байхаар мөн и-оффис системтэй уялдаж ажилладаг нэгдсэн вэб системийг 2022 оны 10 сараас ашиглаж эхэлжээ.

Төрийн захиргааны байгууллагын үйлчилгээ жигд, эрүүл мэнд, боловсролын байгууллагын үйлчилгээ харилцан адилгүй байна.

Орхон аймаг нь газар нутгийн хэмжээ жижиг, төвлөрсөн бүтэцтэй, аймгийн төвийн сум дээрээ хүн амын 97 хувь нь оршин суудаг, 2 сумтай, хөдөөгийн сум нь зэрэгцээ ойрхон оршдог тул бусад газар нутаг томтой, олон сумтай аймаг орон нутгийг бодоход төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байна.

Боловсролын салбарын тухайд аудитын хамрах хугацаа буюу 2013-2023 оны хооронд цэцэрлэгийн зориулалттай барилгыг чөлөөлөх, шинээр барьж байгуулах замаар нийт 10 цэцэрлэг, мөн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, шинээр барьж байгуулах замаар нийт 6 сургууль ашиглалтад оруулсан байна.

Гэвч сургуулийн нэг ангид ногдох хүүхдийн тоо байршил, хэв шинж, сургалтын чанараас шалтгаалан харилцан адилгүй байх ба төвийн сургуулиудад нормоос 5-16 хүүхдээр хэтэрсэн байна.

Мэндцэцэн, Анхны – Оч, Нийцэл, Энхжих мандарваа өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр барьж ашиглалтад оруулж эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Суурьшмал хүн амын тоо их, ойролцоох аймаг, сумдын иргэд ирж тусламж үйлчилгээ авдаг тул аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ачаалал өндөр байна.

Яргуйт, Эрдэнэ, Зэст, Баянцагаан, Говил багт төрийн үйлчилгээ төвлөрсөн нэгдсэн барилгуудыг шинээр барьж ашиглалтад оруулсан.

Төрийн үйлчилгээ цахимжсан нь төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирч байна.

Засгийн газраас 2018 онд e-mongolia төслийг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээг цахим технологид шилжүүлэх, олон шат дамжлагыг багасгах, иргэн, хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх 83 байгууллагын 1,263 төрлийн цахим үйлчилгээг бий болгосон байна.

E-mongolia төслийн хүрээнд 2023-2024 онд “ХУР-ДАН” 2 цэгийн үйлчилгээг нээж, иргэдэд үйлчилж эхэлсэн байна.

“ХУР-ДАН” цэг нь 2023 онд нийт 41,486 иргэнд, 2024 оны 09 сарын байдлаар 33,240 иргэнд үйлчилгээ үзүүлжээ.

Цахим үйлчилгээг бий болгосноор төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирч, иргэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай, шат дамжлагагүй иргэдэд хүргэж байгаа нь иргэдийн цаг хугацаа хэмнэх давуу талтай байна.

“E-office” цахим системд нийт 154 байгууллага бүртгэгдэж, байгууллага хоорондын мэдээ мэдээлэл солилцож байна. Мөн тус программ нь өргөдөл гомдол шийдвэрлэлтийн irgen.erdenet.mn сайттай холбогдож, аймгийн иргэд онлайнаар өргөдөл гомдол, санал хүсэлтээ гаргаж, санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтээ орон зайнаас үл хамааран цаг алдалгүй авч байна.


E-office.mn систем нь улсын хэмжээнд албан бичиг солилцооны дундын системд /www.docx.gov.mn/ холбогдож төрийн 2200 байгууллагатай албан бичиг солилцох бүрэн боломжтой болсон нь төрийн байгууллагын уялдаа холбоотой ажиллахад давуу талтай болжээ.

Авлигатай тэмцэх газраас хийлгэсэн судалгааны тайлангаар Орхон аймгийн ЗДТГ-н шударга байдлын үнэлгээ 2015 оноос 2022 онд 9 байраар сайжирсан байна.

Авлигатай тэмцэх газраас 2013 онд гаргасан аймаг, нийслэлийн авлигад өртөх эрсдэл болон авлигын индексээр³¹ Орхон аймаг 0.61 буюу авлигад өртөх эрсдэл 0.39 гарсан байна. Улсын хэмжээнд авлигад өртөх эрсдэл 2013 онд 0.23-0.54 гарсан бөгөөд Орхон аймаг дээрх үзүүлэлтээрээ 14-р байрт орж байжээ.

³¹ Авлигын индекс нь 0-1 хооронд утга авах бөгөөд 0 бол авлигад автсан, 1 бол огт авлигагүй гэсэн утгатай юм. Иймд авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл урвуу хамааралтай үзүүлэлтүүд юм.


Дүрслэл № 10 Аймаг, нийслэлийн авлигад өртөх эрсдэл болон авлигын индекс.



Авлигын индексийг 2013 оноос хойш ахин тогтоосон талаар баримт материал олдоогүй бөгөөд харин аймгуудын ЗДТГ-н шударга байдлын үнэлгээг гаргасан байна.

Авлигатай тэмцэх газраас болон тус газрын захиалгаар гүйцэтгэсэн шударга байдлын үнэлгээний тайлангаас аймгуудын ЗДТГ-н шударга байдлын үнэлгээг авч үзэхэд Орхон аймгийн ЗДТГ-н шударга байдлын үнэлгээ дараах байдалтай байна.


Дүрслэл №11 Аймгуудын шударга байдлын үнэлгээний үзүүлэлт. /хувиар/



Дээрх дүрслэлээс харахад Орхон аймгийн ЗДТГ нь шударга байдлын үнэлгээгээр 2015 онд 72.2 хувиар 13-т эрэмбэлэгдэж байсан бол хамгийн муудаа 2018 57.8 хувиар 19-р байрт, 2021, 2022 онд 71 хувиар 4-р байрт тус тус эрэмбэлэгдэж байжээ.

Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас зарладаг авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 2013 оноос 2023 он хүртэл дараах байдалтай байна.

Дүрслэл №12 Монгол Улсын авлигын төсөөллийн индекс. /2013-2023 он/



Монгол Улс авлигын төсөөллийн индексээр 2013 онд 175 улсаас 38 оноогоор 83 дугаар байрт орж байсан бол 2023 онд 180 улсаас 33 оноогоор 121 дүгээр байрт орж энэхүү хугацаанд нийт 38 байраар ухарсан байна.

Тус индекс нь 0-ээс 100 онооны системээр улс орнуудыг үнэлдэг бөгөөд 0-д дөхөх тусам авлига их, 100-д дөхөх тусам авлига бага байгааг илтгэдэг байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Яам, агентлаг, аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын бүтцийг Засгийн газраас, бусад байгууллагуудын бүтцийг дээд шатны төсвийн захирагч болон үлгэрчилсэн дүрэм, жишиг стандарт, норм нормативын дагуу тогтоож байна.
- Аймгийн ЗДТГ-н орон тоо нь Засгийн газраас тогтоосон хязгаараас төрийн үйлчилгээний албан хаагчдын тооноос хамааран хэтэрсэн байна.
- Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо бүрэн хангагдаагүй байна.
- Хүний нөөцийн бодлогын цогц баримт бичиг батлаагүй, төрийн албаны хүний нөөцийн бодлогод хяналт үнэлгээ хийгээгүй байна.
- Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо хангалттай ч нарийн мэргэжлийн орон тоог нөхөх иргэн ховор байна.
- Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.
- Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулж баталсан ч төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалын тодорхойлолтыг хянадаггүйгээс байгууллагын удирдлага албан тушаалын чиг үүрэгт тавигдах шаардлагыг тодорхой тусгахгүй баталж байна.
- Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийгээгүйгээс албан тушаалын давхардал, хийдлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.
- Холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоолоор тусгайлан зохицуулснаас бусад нийгмийн баталгаагаар тухайн байгууллагын онцлог, төсөв санхүүгийн боломжоос хамааран харилцан адилгүй хангагдаж байна.
- Зарим тохиолдолд сул орон тооны томилгоог Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх шаардлагатай байна.
- Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан цахим болон танхимаар сургаж байна.
- Төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон зохицуулалтын хүрээнд шилжүүлэн ажиллуулсан байна.
- Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна.
- Төрийн байгууллагын цахимаар үзүүлж буй үйлчилгээг иргэд хүлээн авах боломж, бололцоог олгох талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

- Төрийн захиргааны байгууллагын үйлчилгээ жигд, эрүүл мэнд, боловсролын байгууллагын үйлчилгээ харилцан адилгүй байна.
- Төрийн үйлчилгээ цахимжсан нь төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирч байна.
- Авлигатай тэмцэх газраас хийлгэсэн судалгааны тайлангаар Орхон аймгийн ЗДТГ-н шударга байдлын үнэлгээ 2015 оноос 2022 онд 9 байраар сайжирсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Засаг даргад:

- Төрийн байгууллагын бүтэц орон тоонд чиг үүргийн шинжилгээ хийх

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд:

- Төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын баталгаажуулалт, хувийн хэрэг бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах
- Аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэл, холбогдох мэдээллийн нэгдсэн сантай болох,
- Албан тушаалын тодорхойлолтод тусгасан мэргэжлийн тусгай шаардлагыг хангахгүй албан хаагчдын зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

- Хүний нөөцийн ахлах мэргэжилтний анх дэс түшмэлээр томилсон зөрчлийг шийдвэрлэх.

Эрүүл мэндийн газарт:

- Албан тушаалын тодорхойлолтод тусгасан мэргэжлийн тусгай шаардлагыг хангахгүй албан хаагчийн зөрчлийг шийдвэрлэх

Нийгмийн даатгалын газарт:

- Төрийн албаны зөвлөлөөс төрийн захиргааны ангилал, зэрэглэлээр хянаж, батлах зөвшөөрөл олгосон магадлагч эмчийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэлээр өөрчлөн баталсан зөрчлийг арилгах

Нэгдсэн тайланд тусгуулах санал:

- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон тооны дээд хязгаарыг баталсан Засгийн газрын

тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, албан тушаалын ангиллаар баталж байхыг холбогдох газарт уламжлах,

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар арын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх загвар, нөөц бүрдүүлэх тухай” журам-д өөрчлөлт оруулах,
- “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-д албан хаагчийн хувийн мэдээллийг ХУР системээс татдаг байх, тухайн байгууллагын хүний нөөцтэй холбоотой тайлан мэдээллийг цаг хугацааны давтамжаар татаж авах боломжтой байх, аймгийн Салбар зөвлөл тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэн харах, албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн бүртгэл хийгдсэний дараа харьяалах ТА-ны салбар зөвлөлд мэдээлэл очдог байх зэрэг хөгжүүлэлтийг хийх,
- 2013-2023 онд төрд учруулсан хохирлын бүртгэл хөтөлж, нөхөн төлөлтөд хяналт хэрэгжүүлж, төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргахыг Төрийн албаны зөвлөлд уламжлах.

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ОРГИЛМӨРӨН

Б.БЯМБАТОГТОХ

Ц.ОДГЭРЭЛ

Б.БУЯН-УНДРАХ

Аудитын тайлан баталгаажуулах тушаал:



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/13

Эрдэнэт

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд танилцуулахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), ахлах аудитор (Г.Оргилмөрөн), аудитор (Б.Бямбагтох), (Ц.Одгэрэл) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Холбогдох байгууллагын санал:



ОРХОН АЙМАГ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2024.11.22 № 03/3137

танай _____ -ны № _____ -т

Санал гаргах тухай

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.НАРМАНДАХ ТАНАА

Г.Орчимсүрэн

Аудитаг

11/23

Хүний нөөцийн чиглэлээр аудит хийгдэж дуусаж байгаатай холбогдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Дүгнэлтийн төсөлд байгаа "..... Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыгтодорхойлогдож байна" гэснийг анхаарч хасаж өгөхийг хүсэж байна.

Бид хууль тогтоомжийн дагуу орон тоогоо жил бүр Сангийн ямаар хянуулан батлагдсан төсөвтөө багтаан баталж байгаа бөгөөд төрийн захиргааны албан хаагчдын орон тоог Засгийн газрын шийдвэрээр тогтоосныг мөрдөн ажиллаж байгаа болно.

Мөн дүгнэлтийн төсөлд байгаа "..... Албан тушаалын тодорхойлолтод тусгасан зөрчлийг арилгах арга хэмжээ авах" талаарх зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт буюу томилох эрх бүхий албан тушаалтнуудад өгвөл илүү үр дүнтэй гэсэн санал гаргаж байна.

ДАРГА



Ш.ГАНБОЛД

6124032960

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

№	Аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн санал, тайлбар	Хариу тайлбар
1	Дүгнэлтийн төсөлд байгаа “... Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тодорхойлогдож байна” гэснийг анхаарч хасаж өгөхийг хүсэж байна. Бид хууль тогтоомжийн дагуу орон тоогоо жил бүр Сангийн ямаар хянуулан батлагдсан төсөвтөө багтаан баталж байгаа бөгөөд төрийн захиргааны албан хаагчдын орон тоог Засгийн газрын шийдвэрээр тогтоосныг мөрдөн ажиллаж байгаа болно.	“... Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тодорхойлогдож байна” гэсэн дүгнэлтийг “Аймгийн ЗДТГ-н орон тоо нь Засгийн газраас тогтоосон хязгаараас төрийн үйлчилгээний албан хаагчдын тооноос хамааран хэтэрсэн байна” гэж өөрчлөлт оруулсан.
2	“... Албан тушаалын тодорхойлолтод тусгасан зөрчлийг арилгах арга хэмжээ авах” талаарх зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт буюу томилох эрх бүхий албан тушаалтнуудад өгвөл илүү үр дүнтэй байна.	Албан тушаалын тодорхойлолтыг батлах эрх бүхий албан тушаалтнуудад давхар албан бичгээр тухайн зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлнэ.

Хавсралтууд:

Хавсралт №01 Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлага хангаагүй албан хаагчдын жагсаалт:

Д/д	Байгууллага	Албан тушаал	Эзэмшсэн мэргэжил	АТТ-д заасан мэргэжлийн тусгай шаардлага	Томилсон огноо
1	АЗДТГ	Хэвлэл мэдээллийн ажилтан	Арьсан урлал	Сэтгүүлч	2020.11.18
2	АЗДТГ	Аж ахуйн нярав	Зоо техникч	Нягтлан бодох бүртгэл, санхүү эдийн засаг	2021.12.22
3	Баян-Өндөр сумын ЗДТГ	Нарийн бичгийн дарга	Металл судлал, технологи	Улс төр, нийгэм судлал, эдийн засаг бизнесийн удирдлага	2022.03.22
4	Баян-Өндөр сумын ЗДТГ	Оператор	Бизнесийн эдийн засаг	Улс төр, нийгэм судлал, багш, мэдээллийн технологи	2024.09.10
5	Жаргалант сумын ЗДТГ	Архив бичиг хэргийн эрхлэгч		Боловсрол, хэл, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, сэтгүүл зүй, мэдээлэл, эрх зүй, менежмент ба удирдахуй, маркетинг, зар сурталчилгаа болон бусад	2016.11.11
6	Жаргалант сумын ЗДТГ	Нярав	Багш, сургуулийн өмнөх боловсрол /2024/	Боловсрол, хэл, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, сэтгүүл зүй, мэдээлэл, эрх зүй, менежмент ба удирдахуй, маркетинг, зар сурталчилгаа болон бусад	2018.05.01
7	Байгаль орчны газар	Дарга	Цэргийн инженер	Байгалийн шинжлэл, хүрээлэн буй орчин, хүрээлэн буй орчныг хамгаалах технологи, ойн аж ахуй, аялал жуулчлал.	2016.10.21
8	ХГБХХГ	Дарга	Сэтгүүлч	Эрх зүй, төрийн удирдлага, санхүү, эдийн засаг, нийгмийн ажил, боловсрол	2017.06.12
9	ХХААГ	Нягтлан бодогч	Менежмент маркетинг	Нягтлан бодох бүртгэл	2021.09.01

10	ХХҮГ	Нийгмийн халамжийн хэлтсийн дарга	Англи хэлний орчуулагч	Нийгмийн хамгаалал, эрх зүй, эдийн засаг, боловсрол, сэтгэл судлал, социологи, менежмент	2016.11.02
11	ХХҮГ	Сум хариуцсан мэргэжилтэн	Уран зохиолын багш	Нийгмийн хамгаалал, сэтгэл судлал, хүн ам зүй, эдийн засаг	2013.04.01
12	Нийгмийн даатгалын газар	Тэтгэмжийн байцаагч	Дизайн компьютер график /2009/, Эдийн засаг-нягтлан бодогч /2022/	Нягтлан бодох бүртгэл, санхүү, даатгал, эдийн засаг	2021.10.04
13	УЦУОШГ	Өртөөний цаг уурын техникч	Цэцэрлэгийн багш	Цаг уурын техникч буюу ажиглагч	2024.01.02
14	УЦУОШГ	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааны инженер бөгөөд сүлжээ аюулгүй ажиллагааны ажилтан	Олон улсын бизнесийн удирдлага, худалдаа - бакалавр Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан - Булган МСҮТ Цаг уурын ажиглалт хийх чадамжийн үнэмлэх	УЦУОШГ-ын үүлэнд зориудаар нөлөөлөх экспедицэд ажиллах мэргэжлийн үнэмлэхтэй байх, ХАБЭА-ын сургалтад хамрагдсан зохих мэдлэгтэй байх Цаг агаарт зориудаар нөлөөлөх чиглэлээр мэргэшсэн, компьютер, програмчлал, сүлжээний чиглэлээр мэргэшсэн байх	2023.05.01
15	Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, сургалт хариуцсан мэргэжилтэн	Англи - Орос хэлний орчуулагч инженер, Боловсрол судлал	Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, менежмент ба удирдахуй	2016.10.24
16	Эрүүл мэндийн газар	Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	Био анагаах, дархлаа судлаач	Эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэнд судлаач	2022.01.02
17	БОЭТ	Эрүүл мэндийн даатгал, мэдээлэл технологийн албаны даргыг түр орлон гүйцэтгэгч	Эдийн засаг, статистик	Мэдээлэл зүй, программ хангамж, сүлжээний инженер	2024.06.10
18	БОЭТ	Сүлжээний инженер	Хүний нөөцийн менежмент	Мэдээлэл зүй, программ хангамж, сүлжээний инженер	2024.01.31
19	ХТГ	Эдийн засагч	Нягтлан бодогч	Эдийн засагч	2015.02.02

Хавсралт №02 Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас 2013-2023 онд байгууллагуудад олгосон гэрээт ажилтны мэдээлэл **/мянган төгрөг/**

№	Байгууллагын нэрс	Утга	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	НИЙТ
1	Татварын хэлтэс	Тоо	0		10	12	13	13	13	13	10	10	10	104
		Дүн	0		94,500	158,500	102,230	110,120	173,702	110,173	131,929	131,929	120,935	1,134,018
2	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	Тоо	0	2	4	7	7	7	9	9	9	9	8	71
		Дүн	0	4,496	21,886	43,618	48,481	54,847	78,502	81,198	76,900	79,900	105,187	595,015
3	Цагдаагийн газар	Тоо	0	0	0	0	35	36	34	43	39	40	42	269
		Дүн	0	0	0	0	116,550	106,838	120,250	176,407	133,540	144,104	398,613	1,196,302
4	Улсын бүртгэлийн хэлтэс	Тоо	0	0	0	0	2	4	4	4	4	4	4	26
		Дүн	0	0	0	0	9,341	19,068	22,497	25,017	23,984	21,185	27,832	148,924
5	Нийгмийн даатгалын хэлтэс	Тоо	0	0	0	0	10	10	10	10	10	10	10	70
		Дүн	0	0	0	0	19,432	38,985	57,439	59,198	59,890	59,520	80,000	374,464
6	Хууль эрх зүйн хэлтэс	Тоо	0	0	0	2	2	2	2	2	2	3	4	19
		Дүн	0	0	0	14,352	21,012	20,140	24,190	26,074	26,902	26,902	52,957	212,529
7	Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Сувилахуй/	Тоо	0	0	0	0	0	0	9	9	9	9	9	45
		Дүн	0	0	0	0	0	0	33,600	72,400	78,000	58,500	78,000	320,500
8	Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв /яаралтай тусламж/	Тоо	0	0	0	0	0	0	37	37	37	37	37	185
		Дүн	0	0	0	0	0	0	207,900	158,800	157,600	213,750	285,000	1,023,050
9	Эрх зүйн хөтөч /ухуулагч нарын урамшуулал/	Тоо	0	0	0	0	7	7	7	8	8	9	9	55
		Дүн	0	0	0	0	36,000	36,000	36,000	45,743	45,763	68,040	68,040	335,586
10	Үйлчилгээний нэгдсэн төв	Тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1
		Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	4,852	4,852
НИЙТ		Тоо	0	2	14	21	76	79	125	135	128	131	134	845
		Дүн	0	4,496	116,386	216,470	353,046	385,998	754,080	755,010	734,508	803,830	1,221,416	5,345,240